



УРЬДЧИЛСАН ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1 Энэхүү урьдчилсан төлбөрт үйлчилгээний нөхцөл /цаашид “Үйлчилгээний нөхцөл” гэх/-ийн зорилго нь хэрэглэгчид урьдчилсан төлбөрт үйлчилгээг үзүүлэх нөхцөл, журмыг тодорхойлоход оршино.
- 1.2 Энэхүү үйлчилгээний нөхцөлд дараах нэр, томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
- 1.2.1 “**Нэмэлт үйлчилгээ**” гэж хэрэглэгчийн ашиглаж буй үндсэн үйлчилгээ болох яриа, мессеж, дата хэрэглээнээс бусад нэмэлтээр дуудлаг буй яриа болон мессежид суурилсан үйлчилгээг;
- 1.2.2 “**Үйлчилгээ хооронд шилжих**” гэж Хэрэглэгч дугаар солилгүйгээр ашиглаж буй үйлчилгээний төрөл өөрчлөхийг;
- 1.2.3 “**Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг түр хаах**” гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбар болон дуудлагын төвд хандаж дугаарын гарах яриа, мессеж хаах үйлчилгээг идэвхжүүлэхийг; /түр хаасан тохиолдолд үйлчилгээний хугацаа хэвийн үргэлжилнэ./
- 1.2.4 “**Эзэмших эрх шилжүүлэх**” гэж Хэрэглэгч өөрийн нэр дээр эзэмшиж буй дугаарыг бусдын нэр дээр шилжүүлэх үйлчилгээг;
- 1.2.5 “**Сим карт сэргээх**” гэж Хэрэглэгч дугаараа дахин сэргээх зорилгоор сим карт худалдан авахыг;
- 1.2.6 “**Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт**” гэж Хэрэглэгчийн гарах яриа, мессеж хэрэглээ хийсэн дугаарын жагсаалт болон дата үйлчилгээний хэрэглээний нэгжийн зарцуулалтын мэдээллийг;
- 1.2.7 “**Зүй зохисгүй хэрэглээ**” гэж бусад хэрэглэгчийг залхаах, дарамтлах, гутаан доромжлох,өөр бусад байдалаар бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, сүлжээний хэвийн үйл ажиллагааг саатуулах, нэг дор их хэмжээний мессеж илгээх, зар сурталчилгааны шинжтэй болон хуулиар хориглосон өгөгдөл дамжуулах, бусдад хүндрэл учруулах зэргээр үйлчилгээний нөхцөлд тусгаагүй хэрэглээг;
- 1.2.8 “**Олон улсын яриа үйлчилгээ**” гэж ОУ-ын ярианы гарцыг ашиглан дансан дахь нэгжээр гадаад улс руу дуудлага хийх, мессеж илгээх үйлчилгээг;
- 1.2.9 “**Олон улсын роуминг үйлчилгээ**” гэж Хэрэглэгч гадаад улсад зорчихдоо өөрийн дугаараа ашиглан үйлчилгээг үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан гадаадын операторуудын сүлжээнд холбогдон яриа, мессеж, датаг ашиглах үйлчилгээг тус тус ойлгох;
- 1.2.10 “**4G LTE үйлчилгээ**” гэж интернетээс файл татаж авах, илгээх хурдаараа өндөр хөдөлгөөнт холбооны 4-р үеийн технологи
- 1.2.11 “**eSIM**” гэж үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн QR кодыг уншуулж өөрийн гар утас, төхөөрөмжид биет бус Сим картаар дугаар суулган ашиглах үйлчилгээг;
- 1.2.12 “**ДАН систем**” гэж Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем буюу иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулан ХУР системээс улсын бүртгэл дэх иргэний мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн санд татан авах үйлчилгээг;
- 1.2.13 “**Тоон гарын үсэг**” гэж цахим баримтад зургагдсан гарын үсэг юм. Энэ нь МУ-ын “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн дагуу энгийн гарын үсэгтэй адил хэрэглэгдэнэ. Таны хэвлэмэл материалд үзгээр зурсан гарын үсэгтэй ижил үүрэг, зорилготой баталгаажуулалтын нэг арга, хэлбэр юм.
- 1.2.14 “**PKI SIM**” гэж өндөр нууцдал бүхий тусгай зориулалтын сим карт юм. Үүн дээр таны тоон гарын үсэгийн гэрчилгээ болон утасны дугаар байрладаг.
- 1.2.15 “**Тоон гарын үсэгийг гэрчилгээ**” гэж хэрэглэгчийн хувийн мэдээллийг агуулсан цахим баримт бичиг юм. Мөн энэ нь таны тоон гарын үсэг эзэмших эрх, тоон гарын үсгийн нийтийн түлхүүр, холбогдох бусад мэдээллийг агуулсан байна. Энэхүү баримт бичиг нь баталгаажсан биет болон цаасан гэрчилгээний адил үйлчилнэ.

ХОЁР. ШИНЭ ДУГААР АВАХ

- 2.1 **Шинэ хэрэглэгч болох**
- 2.1.1 Дараах тохиолдолд шинэ хэрэглэгч болох боломжтой. Үүнд:
 - Үйлчилгээний салбарт хандан өөрийн цахим үнэмлэх, хуруугийн хэз уншигчид мэдээллээ өгч;
 - Цахим орчинд ДАН системийн мэдээллээ өгч;
 - Тоон гарын үсэг ашиглах эрх бүхий PKI сим карт авч;
 Хэрэглэгч өөрийн нэр дээр 5 хүртэлх дугаарыг эзэмших эрхтэй.
- 2.1.2 PKI SIM сонгосон хэрэглэгч дугаарын бүртгэлийн хураамж дээр нэмж тоон гарын үсэг агуулсан сим картын төлбөр, гэрчилгээний төлбөр, үйлчилгээний жилийн хураамж төлбөрийг нэмж төлнө;
- 2.2 **Үйлчилгээний хугацаа**
- 2.2.1 Урьдчилсан төлбөрт дугаарыг худалдан авсан өдрөөс эхлэн үйлчилгээний хугацааг тооцно.
- 2.2.2 Урьдчилсан төлбөрт үйлчилгээний дугаарын үндсэн хугацаа дуусмагц хүлээлийн 14 хоногт шилжих ба дугаарын гарах ярианы эрх хаагдаж зөвхөн орох ярианы эрх нээлттэй байна. Хүлээлийн 14 хоног дуусахад дугаарын орох ярианы эрх хаагдаж, 90 хоног дугаарыг хадгална. Нийт 104 хоног дугаарыг хадгална.
- 2.2.3 PKI сим карт авсан урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчийн тоон гарын үсэг ашиглах үйлчилгээний хугацаа 12 сар байна. Үйлчилгээний хураамж 5000 төгрөг ба үйлчилгээ авах үед төлбөрийг төлнө;
- 2.3 **Сим карт сэргээх**
- 2.3.1 Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлд заасан төлбөрийг төлж сим картаа сэргээлгэнэ.
- 2.3.2 Хэрэглэгч анх удаа 3G сим карт авч байгаа тохиолдолд сим картыг хэрэглэгчид үнэгүй олгоно.
- 2.3.3 CDMA системээр ашиглаж байгаа дугаарыг хясаагаар холбодог гар утсанд суулгаж байгаа тохиолдолд сим карт сэргээх төлбөрийг төлнө.
- 2.3.4 Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан 11000 төгрөг төлж өндөр нууцдал бүхий PKI сим картаа сэргээлгэнэ;

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ХООРОНД ШИЛЖИХ

- 3.1 **Хэрэглэгчийн дугаар идэвхтэй төлөвт байгаа тохиолдолд үйлчилгээ хооронд шилжинэ.**
- 3.1.1 Хэрэглэгч тусгай дугаарт мессеж бичин үйлчилгээ хооронд шилжинэ.
- 3.1.2 CDMA сүлжээний хэрэглэгч бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөлд заасан үйлчилгээг сонгох боломжтой.
- 3.1.3 Үйлчилгээ хооронд шилжсэн хэрэглэгчийн нэмэлт үйлчилгээний эрхийг хэвээр шилжүүлэх ба хэрэглэгч тухайн нэмэлт үйлчилгээг цуцлах хүсэлт гаргаагүй бол үргэлжлүүлэн ашиглана.
- 3.2 **Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар түр хаах, нээх**
- 3.2.1 Хэрэглэгч дугаараа түр хаалгах тохиолдолд дуудлагын төв болон үйлчилгээний салбарт хандах, цахим салбараар дан систем болон тоон гарын үсэг ашиглан хувийн мэдээллээ баталгаажуулан хаалгах боломжтой.
- 3.2.2 Дугаар түр хаалгах үйлчилгээг авсан хэрэглэгчийн үйлчилгээний хоног хэвээр үргэлжилнэ.
- 3.2.3 Хэрэглэгч дугаараа нээлгэх хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт хандаж нээлгэх ба үйлчилгээний эрхийг хэрэглэгчийн цахим үнэмлэхийг үндэслэн нээнэ.
- 3.2.4 Үйлчилгээний хоног дууссан тохиолдолд цэнэглэгч картаар цэнэглэн үйлчилгээг үргэлжлүүлэн ашиглана.
- 3.3 **Дараа төлбөрт үйлчилгээ болон Урьдчилсан төлбөрт үйлчилгээ хооронд шилжих**
- 3.3.1 Хэрэглэгч Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжих боломжтой ба энэ тохиолдолд Дараа төлбөрт үйлчилгээний гэрээ байгуулна.
- 3.3.2 Хэрэглэгч Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжихдээ нэгжийн зээлийн үйлчилгээ авсан тохиолдолд нэгжийн зээлийг төлж барагдуулсан байна.
- 3.3.3 Хэрэглэгч Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжих тохиолдолд дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлийн дагуу биллинг цикл рүү шилжих ба дансан дахь нэгж нь илүү төлөлтийн дүн болон орно.
- 3.3.4 Хэрэглэгч Дараа төлбөрт үйлчилгээнээс буцаж Урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих тохиолдолд тухайн үйлчилгээг 3 сараас багагүй хугацаанд тасралтгүй ашигласан, үйлчилгээний нийт төлбөрийг төлсөн байх шаардлагатай.
- 3.3.5 Хэрэглэгч Дараа төлбөрт үйлчилгээнээс буцаж урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү

ДӨРӨВ. ЭЗЭМШИХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

- 4.1 Хэрэглэгч дугаарын эзэмших эрхийг бусдад шилжүүлэх тохиолдолд эрх шилжүүлэгч болон эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр үнэмлэх эсхүл хуруугийн хэз уншигчид тоон гарын үсэг ашиглан үйлчилгээний салбарт хүрэлцэн ирж, үйлчилгээ авна. Хүндэтгэх шалтгаанаар эзэмших эрх шилжүүлэх. Үүнд:
 - Дугаар эзэмшигч нас барсан тохиолдолд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ;
 - Эзэмшигчийн нас барсны гэрчилгээ;
 - Эзэмшигчийн гэр бүлийн гишүүн /гэр бүлийн гишүүн гэдгийг эзэмшигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, насанд хүрсэн төрсөн, дагаар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүүг ойлгоно/ болохыг нотолсон лавлагаа;
 - Дугаарын эрх шилжүүлэн авагч нь өөрийн биеэр цахим үнэмлэхтэй;
 - Дугаар эзэмшигч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа тохиолдолд:
 - Тухайн улсад /гадаадад/ оршин сууж байх нотолсон баримт бичиг;
 - Гадаад паспортын хуулбар;
 - Дугаар эзэмшигч болон хүлээн авагчийн цахим үнэмлэх, хуулбар;
 - Дугаарын эзэмших эрхээ шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай баталгаат гарын үсэгтэй өргөдөл, хүсэлт, өөрийн мэйл хаягаар үнэмлэхийн хуулбар, баталгаат гарын үсгийн хамт илгээх боломжтой;
- 4.2.2 Дугаар эзэмшигч өөрийн нэр дээр шилжүүлэхийг, тодорхой шалтгааны улмаас шилжүүлэх боломжгүй тохиолдолд сүүлийн 12 сар ажилласан хоногтой картын мэдээллийг үндэслэн эрхийг шилжүүлэх боломжтой.

ТАВ. ОЛОН УЛСЫН РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ

- 5.1 Олон улсын роуминг үйлчилгээг авсан тохиолдолд мессеж хүлээн авахад үнэ төлбөргүй, мессеж илгээх, яриа хийхэд тухайн улсын роумингийн тарифыг мөрдөх ба урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгч хүрэлцэхгүй нэгжээр дансаа цэнэглэнэ. Мессеж роуминг үйлчилгээ нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний шинэ хэрэглэгч болох үед автоматаар идэвхжэнэ.
- 5.2 Мессеж роуминг үйлчилгээг ашиглаагүй тохиолдолд нэмэлт төлбөр бодогдохгүй.
- 5.2.2 Мессеж роуминг үйлчилгээний үнэ тариф нь тухайн зорчих бүс нутаг болон орнуудаас шалтгаалан харилцан адилгүй байна.
- 5.2.3 Хэрэглэгч тусгай дугаарт мессеж илгээн мессеж роуминг үйлчилгээг идэвхжүүлэх, цуцлах боломжтой.
- 5.3 Яриа, мессеж хосолсон роуминг үйлчилгээг авах тохиолдолд үйлчилгээний салбар болон тусгай дугаарт мессеж илгээж идэвхжүүлэх, цуцлах боломжтой.
- 5.3.1 Хосолсон роуминг үйлчилгээг авсан тохиолдолд дуудлага хүлээн авахад тухайн улсын дуудлага хүлээж авах тарифыг мөрдөх ба дуудлага хийхэд зорчих буй бүс нутаг болон орнуудаас шалтгаалан харилцан адилгүй байна.
- 5.4 Хэрэглэгч олон улсын роуминг үйлчилгээг ашиглахдаа дараах зүйлийг анхаарна.
- 5.4.1 Хэрэглэгч зорчих улсын мессеж роуминг үйлчилгээний тарифтай урьдчилан танилцах, тусгай дугаарт мессеж илгээх тарифын мэдээлэл авна.
- 5.4.2 Хэрэглэгч хэрэглээгээ тогтмол хянаж, дансыг хангалттай нэгжээр тогтмол цэнэглэн төлбөр тооцоог бүрэн хариуцна.

ЗУРГАА. НЭГЖ ЗАРЦУУЛАЛТ

- 6.1 **Ярианы бүрэн ба бүрэн бүс минутын алхам тооцоолол**
- 6.1.1 Монгол улс доторх үүрэн болон суурин сүлжээ хоорондох яриаг 1(нэг) минутын алхаар тооцох бөгөөд нэг минут хүрээгүй яриаг нэг бүхэл минутаар тооцно. Хэрэглэгчийн хэрэглээ буй үйлчилгээний багцаас хамаарч нэг минутын тариф харилцан адилгүй байна.
- 6.1.2 Зүй зохисгүй хэрэглээ хийсэн бусад хэрэглэгчийг залхаах, сүлжээний хэвийн үйл ажиллагааг саатуулах, нэг дор их хэмжээний мессеж илгээх, зар сурталчилгааны шинжтэй болон хуулиар хориглосон өгөгдөл дамжуулах гэх мэт хэрэглээг урамшуулал нэгжээс тооцохгүй үндсэн нэгжээс тооцно.
- 6.2 **Хэрэглээний мэдээлэл**
- 6.2.1 Хэрэглэгч дансны мэдээллийг *211#, 211 тусгай дугаар руу холболт хийх, Data гэж 123 тусгай дугаарт мессеж илгээн дата хэрэглээний талаарх мэдээллийг тус тус авах боломжтой.
- 6.2.2 Олон улсын роуминг үйлчилгээний тарифын мэдээллийг 599 тусгай дугаарт тухайн улсын нэр болон эхний 4 үсгийг латин үсгээр бичин илгээж мессеж хэлбэрээр авах боломжтой.
- 6.2.3 Skytel аппликейшн ашиглан дансны мэдээлэл шалгах, дата багц, нэмэлт үйлчилгээ идэвхжүүлэх, цуцлах болон олон улсын роуминг үйлчилгээний үнэ тарифын мэдээллийг авах боломжтой.
- 6.2.4 Тоон гарын үсэг үйлчилгээний хугацаа үйлчилгээг авсан өдрөөс 12 сар хүчинтэй ба хүчинтэй хугацаа дуусахад устана. 12 сарын гэрчилгээний төлбөр 22,000 төгрөг, PKI симний төлбөр 11,000 төгрөг байна. Шинээр үйлчилгээ авах үед төлбөрийг төлнө;
- 6.2.5 Тоон гарын үсэг ашиглах гэрчилгээний хугацаа 12 сар. Үг хугацаа нь үндсэн үйлчилгээний хугацаанаас /түр салгалт/ хамааралгүй 12 сар байна;
- 6.3 **Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт**
- 6.3.1 Хэрэглэгч өөрийн биеэр цахим үнэмлэхийн хамт үйлчилгээний үндсэн салбар, хэрэглэгчийн зөвлөх мэргэжилтэнд хандан дэлгэрэнгүй жагсаалт авна.
- 6.3.2 Хэрэглэгч сүүлийн 1 сарын хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт авах боломжтой;
- 6.3.3 Хэрэглэгч хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт авах тохиолдолд дараах үйлчилгээний төлбөрийг төлнө. Үүнд:
 - 1-5 хүртэлх А4 нүүр 0Т,
 - 6-15 хүртэлх А4 нүүр 2000Т
 - 16-аас дээш А4 нүүр 5000Т

ДОЛОО. 4G LTE болон 3G СҮЛЖЭЭНД ШИЛЖИН АЖИЛЛАХ

- 7.1 4G LTE дата багц идэвхжүүлэх үед автоматаар 4G сүлжээ рүү шилжиж ажиллана.
- 7.2 4G LTE дата багцын хугацаа дуусаагүй боловч дата хэмжээ дууссан үед 3G сүлжээ рүү шилжиж ажиллана.
- 7.3 4G LTE дата багцын дата хэмжээ дуусаагүй боловч хүчинтэй хугацаа дууссан үед 3G сүлжээ рүү шилжиж ажиллана.
- 7.4 4G LTE дата багцтай ч сүлжээний хамрах хүрэнээс гарсан тохиолдолд 3G сүлжээ рүү шилжиж ажиллана.
- 7.5 4G LTE болон 3G дата багцуудыг давхар идэвхжүүлэх боломжтой ба 4G LTE сүлжээний хамрах хүрээнд байх үед 4G LTE дата багц түрүүлж ажиллана.
- 7.6 3G сүлжээ рүү шилжихдээ хэрэглэгч 3G сүлжээнд багцтай бол тухайн багцаас, дагагдах багцын хэрэглээ дууссан тохиолдолд задгай тарифаар тооцож ажиллана.

НАЙМ. ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОГСООХ, ЦУЦЛАХ

- 8.1 Урьдчилсан төлбөрт үйлчилгээний дугаарыг 104 хоног хадгалж энэ хугацаанд ашиглаагүй тохиолдолд 105 дахь хоногт тухайн дугаар цуцлагдана.
- 8.2 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр, бичиг баримтын хамт үйлчилгээний салбарт хандаж дугаараа цуцлуулах боломжтой.
- 8.3 Урьдчилсан төлбөрт үйлчилгээг зүй зохисгүй хэрэглэж ашигласан тохиолдолд үйлчилгээг хаана.

ЕС. БУСАД

- 9.1 Энэхүү урьдчилсан төлбөрт үйлчилгээний нөхцөлд шүүд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулах ба Урьдчилсан төлбөрт үйлчилгээний нөхцөлд Үйлчилгээ үзүүлэгч дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.
- 9.2 Үйлчилгээний нөхцөлийн мэдээллийг Скайтел ХХК-ийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд нээлттэй мэдэвлэнэ.
- 9.3 9.1-д заасанчлан нөхцөлд өөрчлөлт оруулсан тохиолдолд Скайтел ХХК-ийн цахим хуудсаар нээлттэй мэдэвлэнэ.